

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Давст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/160/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК-ийн аудитор: А.Дугармаа
Утас: 99542180, Цахим хаяг: baunjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-02-02 №УВА-2026/60/НА-СТН-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давст сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Давст сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


9065555 1525010041

М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Г/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,658,202.65</u>	<u>77,117,505.91</u>
33	АВЛАГА	1,403,252.27	3,372,705.53
335	Бусад авлага	1,403,252.27	3,372,705.53
3351	Байгууллагаас авах авлага	1,403,252.27	3,372,705.53
35	БАРАА МАТЕРИАЛ	36,254,950.38	73,744,800.38
354	Хангамжийн материал	36,254,950.38	73,744,800.38
35410	Бичиг хэргийн материал	2,430,800.00	2,038,750.00
35420	Аж ахуйн материал	33,824,000.00	36,292,100.00
35440	Түлш, шатах тослох материал	150.38	150.38
35470	Бусад хангамжийн материал	00.00	35,413,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,915,516,169.38</u>	<u>2,029,603,137.25</u>
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	1,909,318,169.38	2,023,435,137.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,746,160,531.00	1,750,960,531.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-125,130,691.26	-154,643,366.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73,529,349.60	203,196,749.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,701,222.63	-48,055,868.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,410,444.00	85,850,444.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,711,032.13	-31,418,788.87
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	195,436,425.00	195,486,425.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,000,000.00	10,086,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,000,000.00	-4,351,354.15
39217	Ном	16,324,365.80	16,324,365.80
393	Биет бус хөрөнгө	6,198,000.00	6,168,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,318,000.00	6,318,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-120,000.00	-150,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>1,953,174,372.03</u>	<u>2,106,720,643.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>615,269.65</u>	<u>8,753,075.04</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	615,269.65	8,753,075.04
413	Өглөг	615,269.65	8,753,075.04
4136	Бусад өглөг	615,269.65	8,753,075.04
41361	Байгууллагад төлөх өглөг	615,269.65	6,844,269.04
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,908,806.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,952,559,102.38</u>	<u>2,097,967,568.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,952,559,102.38	2,097,967,568.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	272,796,363.80	272,796,363.80
51101	Өмч: - төрийн	272,796,363.80	272,796,363.80
512	Хуримтлагдсан үр дүн	1,679,762,738.58	1,825,171,204.32
51210	Өмнөх үеийн үр дүн	1,679,762,738.58	1,679,762,738.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	145,408,465.74

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,953,174,372.03	2,106,720,643.16
---	--	------------------	------------------

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	294,379,141.65	473,791,359.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	551,000.00	200,986,659.26
120	Нийтлэг татварын бус орлого	551,000.00	200,986,659.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	551,000.00	200,986,659.26
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,000.00	2,398,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	8,423,359.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,828,141.65	272,804,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	207,916,041.65	202,759,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,916,041.65	202,759,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,912,100.00	70,045,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,912,100.00	70,045,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	326,357,527.51	326,982,893.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,357,527.51	326,982,893.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,907,177.97	323,837,713.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,795,830.17	164,622,590.00
210101	Үндсэн цалин	95,521,773.96	97,794,893.75
210102	Нэмэгдэл	51,187,838.83	56,237,000.00
210104	Урамшуулал	10,086,217.38	10,590,696.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,925,000.00	20,884,386.63
210201	Тэтгэврийн даатгал	13,908,324.02	14,093,562.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,234,675.98	1,662,065.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	797,000.00	902,312.98
210204	Ажилгүйдлийн даатгал	797,000.00	902,312.98
210205	Эрүүл мэндийн даатгал	3,188,000.00	3,324,131.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,350,973.60	85,289,798.76
210301	Гэрэл, цахилгаан	1,461,460.39	1,035,285.55
210302	Түлш, халаалт	83,589,513.21	83,589,513.21
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	665,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,769,700.00	4,472,506.46
210401	Бичиг хэрэг	1,164,300.00	874,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,254,000.00	1,796,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	715,000.00	700,806.46
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	636,400.00	1,101,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	285,000.00	00.00

210604	Урсгал засвар	285,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	680,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,587,180.00	2,650,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,731,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	846,000.00	00.00
210807	Газрын төлбөр	10,180.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,893,494.20	45,238,432.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,402.05	282,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,822,092.15	44,956,432.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,450,349.54	3,145,179.54
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,731,600.00	520,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	951,600.00	520,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,657,623.14	2,624,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,657,623.14	2,624,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,126.40	779.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,126.40	779.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-31,978,385.86	146,808,465.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,400,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,400,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,400,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-31,978,385.86	145,408,465.74

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	294,379,141.65	275,203,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	551,000.00	2,398,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	551,000.00	2,398,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	551,000.00	2,398,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,000.00	2,398,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	293,828,141.65	272,804,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	207,916,041.65	202,759,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,916,041.65	202,759,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,912,100.00	70,045,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,912,100.00	70,045,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	296,632,915.93	269,510,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	296,632,915.93	269,510,800.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,182,566.39	266,365,620.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,798,812.79	166,044,500.00
210101	Үндсэн цалин	95,521,773.96	99,216,803.75
210102	Нэмэгдэл	51,187,838.83	56,237,000.00
210104	Урамшуулал	10,089,200.00	10,590,696.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,925,000.00	20,839,200.00
210201	Тэтгэврийн даатгал	13,549,000.06	14,189,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,594,000.00	1,662,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	797,000.00	831,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	797,000.00	831,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,187,999.94	3,325,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,350,973.60	70,044,420.46
210301	Гэрэл, цахилгаан	1,461,460.39	1,035,285.55
210302	Түлш, халаалт	83,589,513.21	68,344,134.91
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	665,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,100,000.00	2,376,000.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	330,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,796,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	250,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,525,200.00	1,695,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	474,800.00	1,695,000.00
210604	Урсгал засвар	1,050,400.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	680,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,720,180.00	2,650,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,390,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,320,000.00	00.00
210807	Газрын төлбөр	10,180.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	962,400.00	2,036,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	962,400.00	2,036,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,450,349.54	3,145,179.54
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,731,600.00	520,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	951,600.00	520,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,657,623.14	2,624,100.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,657,623.14	2,624,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,126.40	779.54

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,126.40	779.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-2,253,774.28	5,692,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,412,300.00	5,692,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,412,300.00	5,692,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,412,300.00	5,692,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,412,300.00	5,692,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,412,300.00	-5,692,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-11,666,074.28	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,666,074.28	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,359,772,424.51	00.00	1,359,772,424.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,359,772,424.51	00.00	1,359,772,424.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-31,978,385.86	00.00	-31,978,385.86
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,796,363.80	00.00	1,679,762,738.58	00.00	1,952,559,102.38
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	272,796,363.80	00.00	1,679,762,738.58	00.00	1,952,559,102.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	272,796,363.80	00.00	1,679,762,738.58	00.00	1,952,559,102.38

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	145,408,465.74	00.00	145,408,465.74
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	272,796,363.80	00.00	1,825,171,204.32	00.00	2,097,967,568.12

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	274,304,700.00	272,578,320.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,304,700.00	272,578,320.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,784,400.00	272,058,020.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,713,000.00	166,044,500.0
210101	Үндсэн цалин	100,092,300.00	99,216,803.75
210102	Нэмэгдэл	56,237,000.0	56,237,000.00
210104	Урамшуулал	10,383,700.00	10,590,696.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,839,200.00	20,829,200.00
210201	Тэтгэврийн даатгал	14,189,100.00	14,189,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,662,500.00	1,662,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	831,300.00	831,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	831,300.00	831,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,325,000.00	3,325,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,045,200.00	70,044,420.46
210301	Гэрэл, цахилгаан	2,813,100.00	1,035,285.55
210302	Түлш, халаалт	66,035,700.0	68,344,135.91
210303	Цэвэр, бохир ус	1,196,400.00	665,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,310,200.00	2,376,000.00
210401	Бичиг хэрэг	360,000.0	330,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.0	1,796,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200.00	250,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,387,400.00	7,387,400.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	7,387,400.00	7,387,400.00
2107	Томилолт, зочны зардал	750,000.0	680,000.0
210702	Дотоод албан томилолт	750,000.00	680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,698,800.00	2,650,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
210807	Газрын төлбөр	48,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,040,600.00	2,036,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,040,600.00	2,036,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	520,300.00	520,300.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	520,300.00	520,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	520,300.00	520,300.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	275,203,200.00	272,579,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	202,759,500.00	200,135,400.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	202,759,500.0	200,135,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,045,200.00	70,045,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	70,045,200.00	70,045,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,398,500.00	2,398,500.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,398,500.00	2,398,500.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.5	6.5
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.5	3.5
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/төгрөгөөр/	
				Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70.045.200.00	70,044,420.46	779.54	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70.045.200.00	70,044,420.46	779.54	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70.045.200.00	70,044,420.46	779.54	100%

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,045,200.00	70,044,420.46	779.54	100%
210301	Гэрэл цахилгаан	2,813,100.00	1,035,285.55	1,777,814.45	36.8%
210302	Түлш, халаалт	66,035,700.00	68,344,134.91	-2,308,434.19	103.5%
210303	Цэвэр, бохир ус	1,196,400.0	665,000.00	531,400.00	55.6%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,045,200.0	70,044,420.46		100%
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,045,200.00	70,044,420.46		100%
132001	Орон нутгийн төсвөөс	70,045,200.00	70,044,420.46		100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.5	6.5		100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	3.5	3.5		100%
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үндэсний соёлыг өвлүүлэх, хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сэргээн хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Давст сумын Соёлын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Соёлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны тухай хуульд -2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны

өдөр,11 дүгээр сарын 10-ны өдөр,12 дугаар сарын 07-ны өдөр,2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

- ✓ Хөдөлмөр ,нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалда авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Давст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118,132.4 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	1,403.2	3,372.7	1,969.5
Бараа материал	36,254.9	73,744.8	37,489.9
Үндсэн хөрөнгө	1,915,516.1	2,029,603.1	114,087.0
Нийт хөрөнгө	1,953,174.4	2,106,720.6	153,546.2
Өр төлбөр	615.3	8,753.1	8,137.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,952,559.1	2,097,967.6	145,408.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,953,174.4	2,106,720.6	153,546.2

Авлага дансны үлдэгдэл 3,372.7 мянган төгрөг болж 1,969.5 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73,744.8 мянган төгрөг болж 37,489.9 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүмүүсээс хандиваар бусад хангамжийн материал дансанд 35,413.8 мянган төгрөгийн материал авчээ. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,029,603.1 мянган төгрөг болж, 114,087.0 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар хувь хүмүүсээс 89,711.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,097,967.6 мянган төгрөг болж 145,408.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 220,209.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 14,700.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 202,759.5 мянга, орон нутгийн төсвөөс 70,045.2 мянга, нийт 272,804.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 200,135.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 2,398.5 мянга, нийт 202,533.9 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 202,533.9 мянган төгрөгийг зарцуулжээ.

Орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр 70,044.2 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж түлш халаалтын зардалд 68,344.1 мянга, гэрэл цахилгааны зардалд 1,035.3 мянга, цэвэр усны зардалд 665.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 272,578.3 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 668.5 мянга, бараа үйлчилгээний зардал 934.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Тусламжийн орлого төсвөөс/80101	196,790.9	196,790.9	0.00	100%
2	Урлаг уран бүтээл/80214/	5,000.0	3,750.0	1,250.0	75%
3	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт/81855	3438.6	3438.6	0.00	100%

4	Нэмэлт шатны төсвөөс хуваарилсан/83603/	2,398.5	1,500.0	898.5	62.7%
---	---	---------	---------	-------	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамж	-	-	Соёлын төвд программ хангамж байхгүй болно.
2	Унаа,хоолны зардал	-	-	Тайлант жилд унаа хоолны зардал олгоогүй.
3	Сургалт ,семинар	-	-	Тухайн байгууллагад төсөвлөгдсөн зардал байхгүй .
4	Гадаад томилолт,арга хэмжээ	-	-	Гадаад томилолт,арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	-	Тайлант жилд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийгээгүй.
7	Орон тоо	166,713.0	166,044.5	Улаангом сумын Соёлын төв нь 2025 онд 6.0 орон тоотой үйл ажиллагаа явуулж 166,713.0 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 166,044.5 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс,урамшуулалд зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Давст сумын Соёлын төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Давст сумын Соёлын төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Давст сумын Соёлын төв нь 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 6,512.7 мянган төгрөгийн бараа материал, 5,692.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Давст сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан, менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 240,945.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,409.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 326,982.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,269.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,615.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Давст сумын Соёлын төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа мэдээлээгүй 23, хугацаа хоцроож 7 мэдээлэл, хугацаандаа мэдээлсэн 139 шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Давст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Давст сумын Соёлын төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 190.164.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Үр дүнгийн тайланд нийт 190,164.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө 154,751.0 мянга, бараа материал 35,413.8 мянган төгрөгийг орлогоор үр дүнгийн тайланд тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан

зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн тул залрууллаа.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт:

Давст сумын Соёлын төв байгууллагын батлагдсан төсөв 102,794.4 мянган төгрөгийн 1 мэдээлэл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт хэсэгт 35,415.5 мянган төгрөгийн 2 мэдээлэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 68,344.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 137,415.1 мянган төгрөгийн 7 мэдээлэл тус тус хугацаа хоцроож байршуулсан.

Худалдан авах ажиллагааны тайлангийн 1 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор байршуулах 12 мэдээлэл, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 76,892.3 мянган төгрөгийн 5 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 2,584,5 мянган төгрөгийн 5 шийдвэр, бүгд 23 мэдээлэл мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна”, 6.3.2 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт”, 6 дугаар зүйлийн 6.4 хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.8 дахь заалтад “ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд 190,164.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалыг орлогоор тайлагнаагүй	1	190,164.8					1	190,164.8				

Дүн	1					1	190,164.8				
-----	---	--	--	--	--	---	-----------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээлэл байршуулаагүй	1	79,476.8			1	79,476.8						
Дүн	1	79,476.8			1	79,476.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ЗАХИРАЛ, АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/А.ДУГАРМАА/



2026 оны 02 дугаар сарын 02-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/34/24825438
УВА-2026/160/НА-СТА-ТМЗ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Давст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Давст сумын Соёлын төвийн шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 76,892.3 мянган төгрөгийн 5 орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 2,584.5 мянган төгрөгийн 5 шийдвэрийн мэдээлэлийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 103,379.6 мянган төгрөгийн 7 зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 137,415.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Давст сумын Соёлын төвийн дарга Т.Батмагнай, нягтлан бодогч Ц.Бадамсүрэн нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК-НЫ
ЗАХИРАЛ, АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ДУГАРМАА

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ

100

100

100

100

100

100